



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/006-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsoqjargalb@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.24 № 155
танай _____-ны № _____-т

「АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ」
СУМЫН ЗАСАГ ДАРГА Б.ЭНЭБИШ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэмандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Эрдэнэмандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудад 150,012.8 мянган төгрөгийн материаллаг дүнтэй зөрчил илэрч, хязгаарлалттай дүгнэлтүүд авсан;
- Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 7,148.9 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 37 дугаар зүйлийн 37.1-т “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.1-т “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих”, 37.1.5-д “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ”, 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”

гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол, ойжуулалт гэсэн 9 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 3,400,312.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,987,189.7 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 413,122.9 мянган төгрөг зарцуулагдаагүй байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, СДОА, Хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ, Ар саравч ОНӨААТҮГ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2025 онд аймгийн засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 71.9 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,215,352.60	1,544,428.32
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	736,892.75	898,738.40
33	1.1.3 АВЛАГА	305,754.17	428,067.90
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	172,705.67	217,622.02
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,376,253.56	11,414,714.88
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,376,253.56	11,414,714.88
39200	1.2.2.02 Биет хөрөнгө	11,032,267.56	11,073,359.45
39300	1.2.2.03 Биет бус хөрөнгө	343,986.00	341,355.44
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	12,591,606.15	12,959,143.20
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	91,370.14	333,036.78
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	91,370.14	333,036.78
41300	2.1.1.03 Өглөг	91,370.14	333,036.78
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,500,236.02	12,626,106.43
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	12,500,236.02	12,626,106.43
51100	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	1,403,360.52	1,403,360.52
51101	2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/	68,844.00	68,844.00
51200	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	10,933,177.29	11,059,047.70
51300	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	94,854.21	94,854.21
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	12,591,606.15	12,959,143.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	4,072,016.76	4,184,773.35
11	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	910,428.59	1,010,903.68
110	1.1.1.03.1 Орлогын албан татвар	808,958.41	820,148.33
1100	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	808,793.41	869,502.29
1101	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(49,485.96)
1102	1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	165.00	132.00
113	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	56,378.51	128,945.43
118	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	45,091.68	61,809.92
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,188,853.90	3,173,869.67
13	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,972,734.28	-
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,076,145.28	4,057,962.46
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	3,076,145.28	4,057,962.46
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,876,470.18	3,969,513.79
2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,980.84	1,175,505.55
2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,528.63	182,898.63
2103	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	608,119.40	722,314.14
2104	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	68,948.33	169,480.87
2106	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	59,758.60	131,569.02

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2107	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	37,576.00	30,033.00
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	267,656.38	664,643.92
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	879,902.00	893,068.67
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,675.10	88,448.67
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	995,871.49	126,810.89
V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	506,119.62	313.95
VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(506,119.62)	(313.95)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	489,751.87	126,496.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,635,642.24	3,996,282.74
11	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	910,428.59	1,010,903.68
110	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	808,958.41	820,148.33
1100	1.1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	808,793.41	869,502.29
1102	1.1.1.1.03.1.03 Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	165.00	132.00
113	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	56,378.51	128,945.43
118	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	45,091.68	61,809.92
1180	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	31,221.95	31,203.08
1181	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,203.84	16,797.34
1182	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	12,665.89	13,809.51
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	752,479.38	2,985,379.05
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	752,479.38	963,769.39
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	1,807,418.75
123	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	214,190.91
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,972,734.28	-
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,662,774.45	3,253,725.93
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	2,662,774.45	3,253,725.93
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,463,105.35	3,165,277.26
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	996,841.03	1,482,891.82
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	129,642.89	182,898.63
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	667,294.56	748,935.61
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	319,068.66	232,437.83
2106	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	59,758.30	131,568.20
2107	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	37,576.00	30,033.00
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	111,307.42	252,757.51
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	141,616.50	103,754.66

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	199,669.10	88,448.67
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	972,867.79	742,556.80
V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	683,215.92	406,011.15
22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	683,215.92	406,011.15
2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	683,215.92	406,011.15
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(683,215.92)	(406,011.15)
23	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	174,700.00
VII	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	(174,700.00)
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	289,651.87	161,845.65
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	447,240.88	736,892.75
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	736,892.75	898,738.40

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	12,500,236.02	12,500,236.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(0.51)	(0.51)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,500,235.51	12,500,235.51
4	Өмчид гарсан өөрчлөлт	(626.01)	(626.01)
5	Тайлант үеийн үр дүн	126,496.93	126,496.93
6	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,626,106.43	12,626,106.43

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	987,251.60	1,313,577.36	(326,325.76)	133.1
11	Татварын орлого	793,773.50	1,010,903.68	(217,130.18)	127.4
12	Татварын бус орлого	193,478.10	302,673.68	(109,195.58)	156.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,400,312.60	2,987,189.77	413,122.83	87.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,792,795.90	2,550,278.02	242,517.88	91.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,758,680.10	2,517,549.22	241,130.88	91.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,271,142.80	1,175,505.55	95,637.25	92.5

**Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,808.10	144,475.34	14,332.76	91.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	771,048.50	722,314.14	48,734.36	93.7
2104	Хангамж, бараа материалын зардал	148,460.00	119,377.31	29,082.69	80.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	179,727.00	165,565.60	14,161.40	92.1
2107	Томилолт, зочны зардал	36,500.00	27,083.00	9,417.00	74.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,993.70	66,656.83	13,336.87	83.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,000.00	96,571.43	16,428.57	85.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,115.80	32,728.80	1,387.00	95.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,115.80	32,728.80	1,387.00	95.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	428,573.40	262,211.75	166,361.65	61.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	178,943.30	174,700.00	4,243.30	97.6
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	83.00	83.00	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3.00	3.00	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	40.00	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	40.00	40.00	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	181,501.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	181,501.75
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	181,501.75
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	125,781.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,781.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,781.88
2104	Хангамж, бараа материалын зардал	2,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	802.00
2107	Томилолт, зочны зардал	2,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,046.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,683.22
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	100,000.00
222001	Тоног төхөөрөмж	100,000.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй бөгөөд дотоод хяналт, төсвийн орлогыг жигд ханган биелүүлээгүйтэй холбоотой 7,148.9 мянга, орон нутгийн тусгай сантай холбоотой 10,500.0 мянган төгрөг, нийт залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг дүн 17,648.9 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 23,802.2 мянган төгрөгөөс бага байгаа хэдий ч санхүүгийн тайланд нэгтгэгдсэн ЗДТГ, Хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь Хязгаарлалттай дүгнэлт авсан бөгөөд тэдгээрийн залруулагдаагүй зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 7,148.9 мянган төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2 Тайлант онд сумын засаг даргын санхүүгийн алба, төрийн сангаас өдөр тавих хяналт хангалтгүй, дотоод хяналт сул байгаагаас сумын ЗДТГ, Хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ нь аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 37 дугаар зүйлийн 37.1-т “Төрийн сан дараах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.1-т “Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих”, 37.1.5-д “Төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих, Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3 дугаар зүйлийн 3.9.7-д “Энэ журмын 3.9.3.3-т заасан дотоод хяналтыг бүх шатны төрийн сан үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: . Зөрчлийг таслан зогсоож, сумын Засаг даргын дотоод хяналт, сумын санхүүгийн алба, төрийн сангийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.1.3 Тайлант онд малын тоо толгойн албан татварын орлогоос байгаль орчныг бохирдуулсны төлбөрийг хөнгөлөх, сэргийлэх арга хэмжээг төлөвлөн 13,400.0 мянган төгрөг баталж, гүйцэтгэлээр малчдын хог хаягдлын хураамжийн зардалд 10,500.0 мянган төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5.Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр дараах чиг үүргийн хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, төсвийн орлогыг хуулийн дагуу бүрдүүлэхэд арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.1.4 Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хүүгийн авлагыг тухай бүр сангийн программд бүртгэж хуримтлуулдаг боловч нягтлан бодох бүртгэлд хүүгийн авлагыг

хуримтлуулан бүртгэдэггүйгээс санхүүгийн тайлан дахь зээлийн авлагын үлдэгдэл зөрүүтэй тусгагдаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх, 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.3-т Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. .

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, хүүгийн авлагыг нөхөж бүртгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 7,148.9 мянган төгрөгөөр тасарсан	1	7,148.9			1	7,148.9
Дотоод хяналт хангалтгүй	1	0.0			1	0.0
ХХС-ийн хүүгийн авлага бүртгэдэггүй	1	0.0			1	0.0
ОНХС-аас зориулалт бус зарцуулсан	1	10,500.0			1	10,500.0
Нийт дүн	4	17,648.9			4	17,648.9

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	3,409.6	1	3,409.6	1	-
ИТХ	1	3,667.5	1	3,667.5	-	-
Хөгжлийн дэд бүтэц ОНӨААТҮГ	4	118,454.3	1	2,027.9	3	116,426.4
Хоршоо хөгжүүлэх сан	1	0.0			1	0.0
Орон нутгийн хөгжлийн сан	1	10,500.0			1	10,500.0
Төсвийн төвлөрүүлэн захирагч	2	0.0			2	0.0
Дүн	11	136,031.4	3	9,105.0	8	126,926.4